



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,  
Чингис хот, Хэнтий аймаг, 23117  
Утас/Факс: (976) 7056 2412  
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

СУМЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

2023.06.05. № 7/1228  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2023 оны 5 дугаар сарын 15-наас 2023 оны 5 дугаар сарын 20-ны хооронд сумдад ажиллаж сумын Засаг даргын Тамгын газрын бодлогын баримт бичгийн төлөвлөлтөд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулан дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

**Дүгнэлт:** Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг жагсаалт гаргаж хяналтад авсан боловч дутуу, зарим сумд огт хяналтад аваагүйн улмаас аймгийн Засаг даргын 2022 оны А/289 дугаар захирамжаар баталсан хугацаанд хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн биелэлтийг холбогдох газар агентлагууд руу явуулдаг эсэх нь тодорхойгүй, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж эзэнжүүлээгүй байна. Мөн сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний заалт арга хэмжээнүүд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгагдаагүй. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон тасгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс шууд хуулж тавьсан. Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний уялдааг хангаж, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг зөв тодорхойлох.

**Зөвлөмж:**

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалт, арга хэмжээний жагсаалтыг гарган байгууллагын даргаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, суурь түвшинг бүрэн гүйцэд зөв тодорхойлох
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний заалт арга хэмжээг бүрэн тусгах
- Аймгийн Засаг даргын 2022 оны А/289 захирамжийн хавсралтын дагуу тайлангуудыг заасан хугацаанд бүрэн тайлагнаж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хариуцах эзэнг тодорхой болгох.

231060271

- Сумын төсөвт байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж боловсруулах, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах
- Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан өөрт хамааралтай арга хэмжээг гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө зорилт болгож аваад нарийвчлан задлаж оруулах, шалгуур үзүүлэлт болон зорилтод түвшинг зөв тодорхойлох
- Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд алсын хараа-2050 сургалтад хамрагдах, хос бичигтэн болох гэсэн 2 арга хэмжээг нэмж тусгах

Дээрх дүгнэлт, зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 15-ны дотор Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлнэ үү.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ГАНЧИМЭГ

